

БАТЛАВ
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН УҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



УЛААНБААТАР ХОТЫН
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГ

АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр:
Барилга байгууламж буулгах, барих, засварлах ажил гүйцэтгэх-4

Тендер шалгаруулалтын дугаар:
УСУГ/20240101020

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

| | |
|---|----|
| A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ | 7 |
| 1. Тендерийн цар хүрээ..... | 7 |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг..... | 7 |
| 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж | 7 |
| 4. Худалдан авах ажиллагааны цахим систем..... | 7 |
| 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх..... | 7 |
| 6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага | 7 |
| 7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага | 8 |
| B. АГУУЛГА | 8 |
| 8. Тендер шалгаруулалтын баримт бичиг | 8 |
| 9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах | 8 |
| 10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт..... | 9 |
| 11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах | 9 |
| C. ТЕНДЕР БЭЛТГЭХ | 9 |
| 12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл | 9 |
| 13. Тендерийн иж бүрдэл..... | 10 |
| 14. Тендерийн жишиг маягтууд | 10 |
| 15. Хувилбарт санал | 10 |
| 16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг..... | 10 |
| 17. Чадавхын болон туршлагын шаардлага | 11 |
| 18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт .. | 11 |
| 19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт .. | 12 |
| 20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг..... | 12 |
| 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт..... | 12 |
| 22. Тендерийн валют..... | 13 |
| 23. Тендер хүчинтэй байх хугацаа | 13 |
| 24. Тендерийн баталгаа | 13 |
| D. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ..... | 13 |
| 25. Тендер баталгаажуулах, илгээх | 13 |
| 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа | 14 |
| E. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ | 14 |

| | | |
|-----|--|----|
| 27. | Тендерийн талаар тодруулга авах | 14 |
| 28. | Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх..... | 14 |
| 29. | Тендерийг үнэлэх | 14 |
| 30. | Арифметик алдааг залруулах..... | 14 |
| 31. | Давуу эрх олгох | 15 |
| 32. | Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт | 15 |
| 33. | Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох..... | 15 |
| 34. | Тендерийг эрэмбэлэх | 15 |
| 35. | Оролцогчийн чадавхыг дахин магадлах | 15 |
| E. | МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ | 16 |
| 36. | Мэдэгдэл хүргүүлэх | 16 |
| 37. | Гүйцэтгэлийн баталгаа..... | 16 |
| 38. | Урьдчилгаа төлбөр | 16 |
| 39. | Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах..... | 16 |

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “ажил” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.

2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.

3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрднө.

4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан

байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаarahгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б.АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3.Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9. Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай

9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай

| | |
|---|---|
| баримт бичгийг тодруулах | <p>хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.</p> <p>9.2. Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.</p> <p>9.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.</p> <p>9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.</p> <p>9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.</p> |
| 10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт | <p>10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно.</p> <p>10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.</p> |
| 11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах | <p>11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.</p> <p>11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.</p> <p>11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.</p> |
| 12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл | <p>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</p> <p>12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.</p> <p>12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.</p> <p>12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.</p> |

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

14. Тендерийн жишиг маягтууд

15. Хувилбарт санал

16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн

17. Чадавхын болон туршлагын шаардлага

18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

20.1. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.

21.3. Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.4. ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.

21.5. ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг

“тендерийн үнэ” гэж үзнэ.

21.6.Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.7.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2.Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1.Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2.Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.3.Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1.Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан

тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт **Error! Reference source not found.** 7-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бурдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

29.1. Хуулийн 11.4-т зааснаар захиалагч үнэлгээний үндсэн шалгуурыг сонгох бөгөөд өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол үнэлгээний үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

29.2. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.

29.3. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

30. Арифметик алдааг залруулах

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т

- зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн бол хуулийн 8.4, 8.7-т зааснаар үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан эсэхийг дахин магадланна.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 36. Шийдвэр хүргүүлэх** 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
- 37. Гүйцэтгэлийн баталгаа** 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38. Урьдчилгаа төлбөр** 38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.
- 38.3. Урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38.4. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах** 39.1. Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 39.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| | |
|-------------------------------|--|
| ТШЗ-ны холбогдох заалт | А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ |
| ТШЗ 1.1 | Захиалагч: Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ |
| ТШЗ 1.1 | Тендер шалгаруулалтын нэр: Барилга байгууламж буулгах, барих, засварлах ажил гүйцэтгэх. |
| ТШЗ 1.1 | Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: УСУГ/20240101020 |
| ТШЗ 1.2 | Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багц№7: Гүний худгийн барилга буулгаж, барих ажил гүйцэтгэх, Багц№8: Бохир ус тээвэрлэн нийлүүлэх цэг шинээр хийх ажил гүйцэтгэх, Багц№9: Төвийн эх үүсвэрийн Телемеханикийн өрөөний барилгад их засвар хийх ажил гүйцэтгэх, Багц№13: Үйлдвэрийн ХҮТөвийн байрны засварын ажил гүйцэтгэх, Багц№16: Цайны газрын засварын ажил гүйцэтгэх. |
| ТШЗ 1.3 | Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “ Үгүй ” |
| ТШЗ 2.1 | Санхүүжилтийн эх үүсвэр нь: мухайн байгууллагын өөрийн хөрөнгө. |
| ТШЗ 2.1 | Нийт төсөвт өртөг: 354,400,000.00 (гурван зуун тавин дөрвөн сая дөрвөн зуун мянган) төгрөг. Багц№7: 146,400,000.00 (нэг зуун дөчин зургаан сая дөрвөн зуун мянган) төгрөг, Багц№8: 47,000,000.00 (дөчин долоон сая) төгрөг, Багц№9: 40,800,000.00 (дөчин сая найман зуун мянган) төгрөг, Багц№13: 48,000,000.00 (дөчин найман сая) төгрөг, Багц№16: 72,200,000.00 (далан хоёр сая хоёр зуун мянган) төгрөг. |
| Б.АГУУЛГА | |
| ТШЗ 9.1 | Хангамжийн хэлтэс, Хангамжийн инженер Б.Лхагвасүрэн, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Ус Сувгийн Удирдах Газар, Токиогийн гудамж-5, өөрийн байр, 2 дугаар давхар 203 тоот. Утасны дугаар: 70157018-125. Цахим шуудангийн хаяг: [usug1959@gmail.com] |
| ТШЗ 10.1 | Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “ Үгүй ” |
| В. ТЕНДЕР БЭЛТГЭХ | |
| ТШЗ 12.1 | Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл. “Монгол хэл” |

| | |
|-------------------|---|
| ТШЗ 15.1 | Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшилжүүлэхгүй” |
| ТШЗ 16.1.2 | <p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана”</p> <p>1. <i>Монгол Улсын хуулийн дагуу татвар, даатгал, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын, нийгмийн даатгалын, шүүхийн шийдвэр гүйцэтгэх өрөнхий газрын тодорхойлолтуудыг тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд (цахим системээр ирүүлэх) худалдан авалтын цахим системээс өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн даруйд шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай.</i></p> |
| ТШЗ 18.1 | Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардахгүй” |
| ТШЗ 18.2 | Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг: |
| ТШЗ 19.1 | <p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “Шаардахгүй”</p> <p>Ажил гүйцэтгэх хүний нөөц: “Шаардахгүй”</p> <p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “Шаардахгүй”</p> <p>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: “Шаардахгүй”</p> <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардахгүй”</p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: “Шаардана”.</p> <p>1. Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын мэдээлэл.</p> <p>2. Тухайн ажлыг хийж гүйцэтгэх хуваарь ирүүлэх.</p> <p>3. Гүйцэтгэсэн ажил дээрээ 12 сар болон түүнээс дээш хугацааны чанарын баталгаа гаргаж өгөх.</p> <p>4. Өгөгдсөн төсөөт өртгийн нэгдсэн товчоо болон ажлын тоо хэмжээний дагуу хийж ирүүлэх төсөө нь заавал <i>Estimator pro</i> программ дээр хийгдсэн байх ба эрх бүхий төсөөвчний тамга, гарын үсгээр баталгаажсан байх.</p> <p>5. Тухайн ажил гүйцэтгэх төсөө нь шаардлагад нийцсэн байх /Өгөгдсөн төсөөт өртгийн нэгдсэн товчооны дагуу захиалагчийн болон зохиогчийн хяналтын зардлыг нормын дагуу тооцсон байх, ажлын тоо хэмжээ дутуу болон дээрх шаардлагыг хангаагүй төсвийг шаардлага хангаагүй гэж үзэн тендерээс татгалзах үндэслэл болно/.</p> <p>6. Тендерт оролцогч нь ажлын талбайтай биечлэн танилцаж хийгдэх ажлын талаар өрөнхий мэдээлэл, заавар авсан байх ба ажлын тоо хэмжээ болон ажлын талбайг хүлээн зөвшөөрч буй тухайгаа ажлын талбайтай танилцсан зураг, тайлбарын хамт албан бичгээр ирүүлэх.</p> <p>7. Тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд гарч болзошгүй эрсдлийг тооцон доорхи “Эрсдэлийн үнэлгээ” хийх хуудсын дагуу үнэлгээ хийж дүгнэлтийн хамт ирүүлэх.</p> <p>8. Гүйцэтгэгч байгууллага нь гэрээт ажил дээр ажиллах ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг бүрэн</p> |

| | |
|-------------------------------|---|
| | <p><i>хариуцаж ажиллах, хүн нэг бүрийг хамгаалах хэрэгслээр хангаж ажиллах тухайгаа албан бичгээр ирүүлэх.</i></p> <p>9. Тендерт оролцогч нь манай байгууллагын шийдвэр гаргах түвшиний албан тушаалтан, инженер техникийн ажилтануудтай нийтийн албананд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5, 3.1.6, 11.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй болохыг илэрхийлсэн албан бичиг ирүүлэх. Хэрэв дээрх нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно. /Дээрх нөхцөл үүссэндийг нуун дарагдуулсан болон худал мэдүүлснээс гарах үр дагаврыг үнэлгээний хороо нь хариуцахгүй болно/</p> <p>10. Тендерийн баримт бичиг нь үнэн зөв, тодорхой гаргацтай байна. Унших боломжгүй, тодорхойгүйн улмаас үнэлгээ хийх боломжгүй нөхцөл байдал үүсэхээр бол үнэлгээний хороо нь уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>11. Дээр заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p> |
| ТШЗ 19.2 | Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг: |
| ТШЗ 19.3 | <p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана”</p> <p>Бүх багц дээр: БА-2.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил</p> <p>БА-3.1 Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил</p> <p>Дээрх тусгай зөвшөөрлүүдийн аль нэгтэй байх</p> <p>/Дээрх тусгай зөвшөөрөлүүдтэй дүйцэхүйц болон түүнээс дээшихи тусгай зөвшөөрөлтэй байж болно/</p> |
| ТШЗ 21.6 | Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтолцол байна” |
| ТШЗ 24.1 | <p>Тендерийн баталгааны дүн:</p> <p>Багц №7: 732,000.00 (долоон зуун гучин хоёр мянган) төгрөг.</p> |
| Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ | |
| ТШЗ 25.5 | <p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тухайн ажлыг хийж гүйцэтгэх хуваарь ирүүлэх. 2. Гүйцэтгэсэн ажил дээрээ 12 сар болон түүнээс дээш хугацааны чанарын баталгаа гаргаж өгөх. 3. Өгөгдсөн төсөөвт өртгийн нэгдсэн төвчоо болон ажлын тоо хэмжээний дагуу хийж ирүүлэх төсөөв нь заавал Estimator pro программ дээр хийгдсэн байх ба эрх бүхий төсөөвчний тамга, гарын үсгээр баталгаажсан байх. 4. Тусгай зөвшөөрөл. <p>Анхааруулга: Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт</p> |

| | |
|--|---|
| | оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| ТШЗ 26.1 | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр. Цаг: 09 цаг 00 минут. |
| ТШЗ 26.2 | Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Цаг: 09 цаг 10 минут. Тендер нээх газрын хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Ус Сувгийн Удирдах Газар, Токиогийн гудамж-5, өөрийн байр, 2 дугаар давхар 203 тоот. |
| Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ | |
| ТШЗ 31.1 | Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: |
| ТШЗ 32.1 | Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй” |
| Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ | |
| ТШЗ 37.1 | Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “Тийм” Багц№7 дээр гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ. |
| Ё. БУСАД | |
| ТШЗ 38.1 | Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй” |

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

**Багц№7: Гүний худгийн барилга буулгаж, барих ажил гүйцэтгэх-/2 ширхэг/
Доорхи ажлын тоо хэмжээ нь зөвхөн 1 гүний худаг буулгаж, барих ажлын тоо
хэмжээ болохыг анхаарна уу.**

УСУГ-УХА-ҮЭҮ-1-р өргөгчийн гүнийн худаг

1-р өргөгчийн гүнийн худаг буулгаж шинээр барих ажил

ТӨСӨВТ ӨРТГИЙН НЭГДСЭН ТОВЧОО

| Д/Д | Зардлын нэр |
|-----|--|
| 1 | Ажиллах хүчний зардал |
| 2 | Материал |
| 3 | Тээвэр |
| 4 | Машин ашиглалт |
| | Шууд зардлын дүн |
| 5 | Нэмэгдэл зардал /72.3 %/ |
| 6 | Ашиг / 15%/ |
| | Барилга угсралтын ажлын дүн |
| 7 | НӨАТ 10% |
| 8 | Нормчлолын сан 0.18% |
| | Дүн |
| 9 | Захиалагчийн албаны зардал |
| 10 | Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн |
| 11 | Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал |
| | Дүн |
| 12 | Магадлашгүй ажил 2 % |
| 13 | Бусад нэмэлт зардал |
| | Дүн |

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

БУУЛГАХ АЖИЛ

| Д/Д | Ажлын нэр | Нэгж | Тоо хэмжээ |
|-----|---|-----------|------------|
| 1 | Ханын хаалга цонхны хайрцаг задалж буулгах | 1хайрцаг | 3 |
| 2 | Хаалганы хавтас авах | хайрцаг | 2 |
| 3 | Тальны зам төмөр буулгах | м | 6 |
| 4 | Тааз , хананд бэхэлсэн гэрэлтүүлэгч буулгах | 100м | 0.02 |
| 5 | Унтраалга разетка , автомат буулгах | 100ш | 0.03 |
| 6 | Төрөл бүрийн удирдлагын самбаруудыг буулгах | иж бүрдэл | 2 |
| 7 | Газардуулгын хүрээ, аянга зайлцуулгачийн төмөр хийцийг буулган авах | 100м | 1 |
| 8 | Хар цаасан дээвэр задалж буулгах | м2 | 25 |
| 9 | Цементэн тэгшилгээ ховхлож буулгах | м2 | 25 |
| 10 | Өндөр хүчин чадалтай нураах алхаар тоосгон хана буулгах | м3 | 28.8 |
| 11 | Барилгын хог ялгаж овоолох ба автомашинд ачих | м3 | 39.8 |
| 12 | Худгаас буусан материалыг складанд тээвэрлэн хүргэж буулгах | тн | 6.8 |

СУУРИЙН АЖИЛ

| Д/Д | Ажлын нэр | Нэгж | Тоо хэмжээ |
|-----|---|------|------------|
| 1 | Бетон бэлтгэл хийх В5 | м3 | 1.6 |
| 2 | Бетон шугаман суурь цутгах В15 | м3 | 15.94 |
| 3 | Суурийн ус тусгаарлагчийг битум түрхлэгээр 2 ўе хийх | м2 | 56.48 |
| 4 | Суурийн хажуугаар овойлт үүсгэхгүй хөрсөөр нягтуулж булах | м3 | 1.85 |

ХАНЫН ӨРЛӨГИЙН АЖИЛ

| Д/Д | Ажлын нэр | Нэгж | Тоо хэмжээ |
|-----|---|------|------------|
| 1 | Ердийн тоосгоор энгийн гоёлтой 380 мм-ийн тоосгон хана цемент шохойн зуурмагаар гагнаж өрөх | м3 | 27.09 |
| 2 | 1/2 өнгөлгөөны тоосгоор гадна хана өнгөлж өрөх | м2 | 71.3 |
| 3 | Ханын тор | тн | 0.16 |
| 4 | Ялуу я15.12.14 | ш | 2 |
| 5 | Төмөр бетон бүс цутгах В15 | м3 | 2.1 |

ХУЧИЛТ ДЭЭВРИЙН АЖИЛ

| Д/Д | Ажлын нэр | Нэгж | Тоо хэмжээ |
|-----|---|------|------------|
| 1 | Хучилтын банзан бамбай угсрах | м2 | 32.4 |
| 2 | Дээврийн 1 ўе наамал уур тусгаарлагч хийх | м2 | 32.4 |
| 3 | Хөөснөнцөрөн хавтан дулаалга хийх б=100мм g=35кг/м3 | м2 | 32.4 |
| 4 | Хучилтанд 15мм зузаан тортой цементэн тэгшилгээ хийх | м2 | 32.4 |
| 5 | Банзан шувуу нуруу угсрах | м3 | 1.06 |
| 6 | Хучилтын бэхэлгээний төмөр хийц суулгах | тн | 0.02 |
| 7 | Парпетны хананд суух хэсгийн модон дам нуруунд язралтаас хамгаалах хар тосон түрхлэг хийх | м2 | 4.32 |
| 8 | Модон сараалжтай долгионт төмөр дээвэр хийх | м2 | 47.52 |
| 9 | Барилгын гадна талын төмөр эдлэлүүд ус зайлцуулах хоолойн хамт хийх | м2 | 38.52 |

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

ШАЛНЫ АЖИЛ

| Д/Д | Ажлын нэр | Нэгж | Тоо хэмжээ |
|-----|--------------------------------------|------|------------|
| 1 | Бетон шал цутгах В10 б=150мм | м3 | 3.62 |
| 2 | 20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх | м2 | 24.2 |

ШАТ, ДОВЖООНЫ АЖИЛ

| Д/Д | Ажлын нэр | Нэгж | Тоо хэмжээ |
|-----|--|------|------------|
| 1 | Довжоог төмөр бетон гишгүүрийн хамт цутгах В15 | м3 | 0.68 |
| 2 | Бетон ба дэвсгэр үеийг арматурчилах /зөрүү/ | тн | 0.11 |
| 3 | Хаяавч цутгах В5 | м3 | 1.83 |
| 4 | Хаяавчинд 20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх | м2 | 18.3 |

ХААЛГА, ЦОНХНЫ АЖИЛ

| Д/Д | Ажлын нэр | Нэгж | Тоо хэмжээ |
|-----|--|------------|------------|
| 1 | Пластмасан цонх хананд суулгах | 1 блок | 1 |
